Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүний найрлаган дахь сүү нь кальциар баялаг тул бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжихээс гадна хүүхдийн будаа нь нүүрс усаар баялаг тул амин дэм, эрдэс бодисын зохистой хэрэгцээг хангах зориулалтаар хэрэглэнэ.

Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Кашийг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.

- Кашийг үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
  1. Үндсэн түүхий эд – Сүү
  2. Туслах түүхий эд – Хүүхдийн будаа
  3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Элсэн чихэр, давс, тос
- Каш нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
  1. Амт үнэр – Нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй байна.
  2. Өнгө – Сүүн цагаан өнгөтэй байна.
  3. Тунгалагжилт, биет байдал – Шингэвтэр байдалтай, хүүхдийн будаа сүү жигд сайтар холигдсон нэгэн төрлийн шингэн байна.

Дагалдах бүтээгдэхүүн: - Талх

ТАЛХНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

8. **Бүтээгдэхүүний нэр:** Талх
9. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Жорын дагуу халуун бүлээн усанд хөрөнгө исгэн тогтворжуулж гурил болон нэмэлт бүтээгдэхүүнүүдийг хийж болгосон. Нэр төрөлдөө тохирсон амт, үнэртэй, найрлагандаа гадны хольцгүй, гүйцэд бололттой, гонзгой хэлбэртэй, шаргал өнгөтэй байна. Илчлэг нь 162,7 ккал, ууараг 5,9%, өөх тос 4,2%, нүүрс ус 26,4% агуулагдна.
10. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүн нь нүүрс усаар баялаг тул хүүхдийн булчингийн үйл ажиллагааны илчлэгийн эх үүсвэрийг хангах зориулалтаар хэрэглэнэ.
11. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Талхыг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Талх үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
      1. Үндсэн түүхий эд – Гурил
      2. Туслах түүхий эд – Хөрөнгө
      3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Элсэн чихэр, сүү, тос, өндөг
    - Талх нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
      1. Амт үнэр – Нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй байна.
      2. Өнгө – Шаргал өнгөтэй байна.
      3. Тунгалагжилт, биет байдал – Гонзгой хэлбэртэй, сийрэгжилт жигд, зөөлөн байна.

Үдийн цайнд санал болгож буй хосмог бүтээгдэхүүн №3

Буцалгасан аарц, варьентай талхны техникийн тодорхойлолт

Зураг №3

Тайлбар: Буцалгасан аарц 200гр, варьентай талх 55гр

Үндсэн бүтээгдэхүүн: -Буцалгасан аарц

БУЦАЛГАСАН ААРЦНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Буцалгасан аарц

12. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Жорын дагуу усанд түүхий аарцыг буцалгаж болгосон. Нэр төрөлдөө тохирсон амт, үнэртэй, найрлагандаа аарц, гурил, ус, элсэн чихэр, цөцгийн тос агуулсан, гадны хольцгүй, гүйцэд бололттой. Илчлэг нь 257,3 ккал, ууараг 8,2%, өөх тос 13,5%, нүүрс ус 25,9% агуулагдна.
13. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүний найрлаган дахь аарц нь кальциар баялаг тул бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжихээс гадна амин дэм, эрдэс бодисын зохистой хэрэгцээг хангах зориулалтаар хэрэглэнэ.
14. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Аарцыг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Аарцыг үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Аарц
        2. Туслах түүхий эд – Гурил
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Элсэн чихэр, давс, тос
    - Аарц нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр – Нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй байна.
        2. Өнгө –Аарцныхаа онцлогоос шалтгаалсан цайвардуу өнгөтэй байна.
        3. Тунгалагжилт, биет байдал – Шингэвтэр байдалтай, аарц нь туслах болон нэмэлт бүтээгдэхүүнүүдтэйгээ жигд сайтар холигдсон нэгэн төрлийн шингэн байна.

Дагалдах бүтээгдэхүүн: - Варьентэй талх

ВАРЬЕНТАЙ ТАЛХНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

15. **Бүтээгдэхүүний нэр:** Варьентай талх
16. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Жорын дагуу бэлтгэсэн зуурмагныхаа голд жимсний чанамал хийж жигнэж болгосон. Талхан бүтээгдэхүүний болон жимс, жимсгэний охь амт, үнэртэй, найрлагандаа гадны хольцгүй, гүйцэд бололттой, цэцгэн дугуй хэлбэртэй, улбар шаргал өнгөтэй байна. Илчлэг нь 195,4 ккал, ууараг 6,5%, өөх тос 4,5%, нүүрс ус 33,8% агуулагдна.
17. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүн нь нүүрс усаар баялаг тул хүүхдийн булчингийн үйл ажиллагааны илчлэгийн эх үүсвэрийг хангахаас гадна шанз болох жимсний чанамал нь хүүхдийн бие физиологит шаардлагатай витаминаар тэтгэх зориулалтаар хэрэглэнэ.
18. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: варьентай талхыг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Талх үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        4. Үндсэн түүхий эд – Гурил
        5. Туслах түүхий эд – Жимсний чанамал
        6. Баяжуулагч хүнсний нэмэлт – Элсэн чихэр, сүү, тос, өндөг
    - Талх нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        4. Амт үнэр – Талхан бүтээгдэхүүний болон жимс, жимсгэний охь амт, үнэртэй байна.
        5. Өнгө – Улбар шаргал өнгөтэй байна.
        6. Тунгалагжилт, биет байдал – Цэцгэн дугуй хэлбэртэй, сийрэгжилт жигд, дундаа жимсний чанамалтай байна.

Багц №1 **Махан хоол бүтээгдэхүүн**

Үдийн цайнд санал болгож буй бүтээгдэхүүн №1

Мах ногооны зутан шөлний техникийн тодорхойлолт

Зураг №1

Тайлбар: Мах ногооны зутан шөл 200 гр

Үндсэн бүтээгдэхүүн: -Мах ногооны зутан шөл

МАХ НОГООНЫ ЗУТАН ШӨЛНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Мах ногооны зутан шөл

19. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Урьдчилж бэлтгэсэн ясны шөлөнд жижгэлж бэлтгэсэн мах болон төмс лууванг холин сүү, масло, гурилаар найруулж буцалгаж бэлэн болгосон бүтээгдэхүүн. Мах, махан бүтээгдэхүүний өвөрмөц амт үнэртэй, найрлагандаа мах болон ногоо агуулсан, гадны нэмэлт хольцгүй, гүйцэд бололттой. Илчлэг нь 264,7 ккал, уураг 10,8%, өөх тос 8,2%, нүүрс ус 18,8% агуулагдна.
20. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүн нь амьтны гаралтай ууараг, өөх тосоор баялаг тул бага насны хүүхдийн бие мах бодид бодисын солилцоог хангаж, эд эсийн нөхөн төлжилтийг хангаж, биенийхээ халуун хэмийг тогтмол барьж эрүүл байх үндсэн хэрэгцээг хангах зориулалтаар хэрэглэнэ.
21. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Мах ногооны зутан шөл нь батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Мах ногооны зутан шөлийг үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Мах
        2. Туслах түүхий эд – Төмс, лууван
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Сүү, масло, гурил, давс
    - Мах ногооны зутан шөл нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр – Мах, махан бүтээгдэхүүний өвөрмөц амт үнэртэй байна.
        2. Өнгө – Гүйцэд болсон мах, махан бүтээгдэхүүний үндсэн бор өнгөтэй байна.
        3. Тунгалагжилт, биет байдал – Өтгөвтөр, мах ногоо нэгэн жигд сайтар холигдсон нэгэн төрлийн шингэн байна.

Үдийн цайнд санал болгож буй хосмог бүтээгдэхүүн №2

Пирожки, сүүтэй цайны техникийн тодорхойлолт

Зураг №2



Тайлбар: Пирожки 120 гр, бор цай 200 гр

Үндсэн бүтээгдэхүүн: -Пирожки

ПИРОЖКИНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Пирожки

22. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Пирожки нь улаан шаргал өнгөтэй, зөөлхөн гурил нь чимхээд тавихад босч хуучин байдалдаа ордог, тос сахар, давсны хосолсон сайхан амттай, шанз нь бутармал шинжтэй сайхан амт үнэртэй байна. Илчлэг нь 313,7 ккал, уураг 16,3%, өөх тос 11,5%, нүүрс ус 38,3% агуулагдна.
23. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүн нь амьтны гаралтай уураг, өөх тосоор баялаг тул бага насны хүүхдийн бие мах бодид бодисын солилцоог хангаж, эд эсийн нөхөн төлжилтийг хангаж, биенийхээ халуун хэмийг тогтмол барьж эрүүл байх үндсэн хэрэгцээг хангах зориулалтаар хэрэглэнэ.
24. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Пирожки нь батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Пирожкийг үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Мах
        2. Туслах түүхий эд – Гурил
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Ногоо, будаа, тос, давс
    - Пирожки нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр – Мах махан бүтээгдэхүүний өвөрмөц амт үнэртэйгээс гадна тос сахар, давсны хосолсон сайхан амттай
        2. Өнгө – Улаан шаргал өнгөтэй
        3. Тунгалагжилт, биет байдал – Зөөлхөн гурил нь чимхээд тавихад босч хуучин байдалдаа ордог, шанз нь бутармал шинжтэй байна.

Дагалдах бүтээгдэхүүн: - Сүүтэй цай

БОР ЦАЙНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Бор цай

25. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Жорын дагуу ус давс, цайны хандыг тохируулж хийж болгосон. Нэр төрөлдөө тохирсон амт, үнэртэй, найрлагандаа гадны хольцгүй, гүйцэд бололттой, шингэн, бор шаргал өнгөтэй байна. Илчлэг нь 40 ккал, уураг 2,4%, өөх тос 1,8%, нүүрс ус 2,4% агуулагдна.
26. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүнийг халуун хоол, хуурай хүнсэнд дагалдах шингэн уух зүйлийн зориулалтаар хэрэглэнэ. Амны цангаа тайлах хүүхдийн биен дэх шингэний алдагдлыг нөхөх зэргээр хэрэглэнэ..
27. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Сүүтэй цайг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Талх үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Ногоон цай
        2. Туслах түүхий эд – Ус
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт –Давс
    - Сүүтэй цай нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр –Ногоон цайны тохирсон сайхан амт үнэртэй байна.
        2. Өнгө – Бор шаргал өнгөтэй байна.
        3. Тунгалагжилт, биет байдал – Хуурай цайг сайтар шүүсэн тунгалаг шингэн байна.

Үдийн цайнд санал болгож буй бүтээгдэхүүн №3

Каш махны зутан шөлний техникийн тодорхойлолт

Зураг №3

Тайлбар: Каш махны зутан шөл 200 гр

Үндсэн бүтээгдэхүүн: -Каш махны зутан шөл

КАШ МАХНЫ ЗУТАН ШӨЛНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Каш махны зутан шөл

28. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Урьдчилж бэлтгэсэн ясны шөлөнд жижгэлж бэлтгэсэн мах болон хүүхдийн будаа, лууванг холин найруулж буцалгаж бэлэн болгосон бүтээгдэхүүн. Мах, махан бүтээгдэхүүний өвөрмөц амт үнэртэй, найрлагандаа мах болон хүүхдийн агуулсан, гадны нэмэлт хольцгүй, гүйцэд бололттой. Илчлэг нь 195,2 ккал, ууараг 10,6%, өөх тос 10,1%, нүүрс ус 17,7% агуулагдна.
29. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүн нь амьтны гаралтай ууараг, өөх тосоор баялаг тул бага насны хүүхдийн бие мах бодид бодисын солилцоог хангаж, эд эсийн нөхөн төлжилтийг хангаж, биенийхээ халуун хэмийг тогтмол барьж эрүүл байх үндсэн хэрэгцээг хангах бөгөөд хүүхдийн будаа нь нүүрс усаар баялаг тул хүүхдийн булчингийн үйл ажиллагааны илчлэгийн эх үүсвэрийг хангах зориулалтаар хэрэглэнэ.
30. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Каш махны зутан шөл нь батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Мах ногооны зутан шөлийг үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Мах
        2. Туслах түүхий эд – Хүүхдийн будаа, лууван
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Давс, сонгино
    - Каш махны зутан шөл нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр – Мах болон хүүхдийн будааны өвөрмөц амт үнэртэй байна.
        2. Өнгө – Гүйцэд болсон мах, махан бүтээгдэхүүний үндсэн бор өнгөтэй байна.
        3. Тунгалагжилт, биет байдал – Өтгөвтөр, мах болон хүүхдийн будаа нэгэн жигд сайтар холигдсон нэгэн төрлийн шингэн байна.

Үдийн цайнд санал болгож буй хосмог бүтээгдэхүүн №4

Махан ороомог, сүүтэй цайны техникийн тодорхойлолт

Зураг №4

Тайлбар: Махан ороомог 110 гр, сүүтэй цай 200 гр

Үндсэн бүтээгдэхүүн: -Махан ороомог

МАХАН ОРООМОГНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Махан ороомог

31. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Махан ороомог нь шаргал өнгөтэй, зөөлхөн гурил нь чимхээд тавихад босч хуучин байдалдаа ордог, жижиглэн амталсан махан шанзтай, сайхан амт үнэртэй, гуриландаа махан шанзаа ороосон байдалтай, байна. Илчлэг нь 307 ккал, ууараг 16,1%, өөх тос 11,5%, нүүрс ус 36,8% агуулагдна.
32. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүн нь амьтны гаралтай ууараг, өөх тосоор баялаг тул бага насны хүүхдийн бие мах бодид бодисын солилцоог хангаж, эд эсийн нөхөн төлжилтийг хангаж, биенийхээ халуун хэмийг тогтмол барьж эрүүл байх үндсэн хэрэгцээг хангах зориулалтаар хэрэглэнэ.
33. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Махан ороомог нь батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Махан ороомгийг үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Мах
        2. Туслах түүхий эд – Гурил
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Сонгино, тос, давс
    - Махан ороомог нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр – Мах махан бүтээгдэхүүний өвөрмөц амт үнэртэйгээс гадна тос сахар, давсны хосолсон сайхан амттай
        2. Өнгө – Шаргал өнгөтэй
        3. Тунгалагжилт, биет байдал – Зөөлхөн гурил нь чимхээд тавихад босч хуучин байдалдаа ордог, шанз нь нийлмэл, бутармал бус шинжтэй байна.

Дагалдах бүтээгдэхүүн: - Сүүтэй цай

СҮҮТЭЙ ЦАЙНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

34. **Бүтээгдэхүүний нэр:** Сүүтэй цай
35. **Бүтээгдэхүүний тодорхойлолт**: Жорын дагуу ус сүү, цайны хандыг тохируулж хийж болгосон. Нэр төрөлдөө тохирсон амт, үнэртэй, найрлагандаа гадны хольцгүй, гүйцэд бололттой, шингэн, цайвар шаргал өнгөтэй байна. Илчлэг нь 40 ккал, уураг 2,4%, өөх тос 1,8%, нүүрс ус 2,4% агуулагдна.
36. Бүтээгдэхүүний зориулалт: Уг бүтээгдэхүүний найрлаган дахь сүү нь кальциар баялаг тул бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжихээс гадна хүүхдийн хоногийн шингэний хэрэгцээг хангах зориулалтаар хэрэглэнэ.
37. Чанарын түвшин, техникийн үзүүлэлт: Сүүтэй цайг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд /гал тогоонд/ үйлдвэрлэнэ.
    - Талх үйлдвэрлэхэд түүхий эд, материал, хүнсний нэмэлт нь Монгол улсын болон Олон улсын (ISO), хүнсний эрхзүйн хороо (CAC)-ны стандартын шаардлага хангана.
        1. Үндсэн түүхий эд – Сүү
        2. Туслах түүхий эд – Ус
        3. Баяжуулагч хүнсний нэмэлт – Хуурай цай, давс
    - Сүүтэй цай нь мэдрэхүйн үнэлгээгээр доорх шаардлагыг хангана.
        1. Амт үнэр – Сүү, ногоон цайны тохирсон сайхан амт үнэртэй байна.
        2. Өнгө – Цайвар шаргал өнгөтэй байна.
        3. Тунгалагжилт, биет байдал – Хуурай цайг шүүсэн шингэн, сүү нь сайтар ууссан байна.

БСШУ-ны Сайдын 2006 оны 08 сарын 20-ны
өдрийн 301 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД "ҮДИЙН ЦАЙ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Ерөнхий боловсролын сургуулийн нэг, хоёр дугаар ангийн сурагчдад тэдний нас бие бялдарын онцлог хэрэгцээнд тохирсон эрүүл ахуйн шаардлага хангасан үдийн цайгаар үйлчлэх үйлчилгээг зохион бхйгуулахад энэхүү зөвлөмжийг мөрдлөгө болгоно.

Сургуулийн цайны газар, гал тогоотой сургуулийн хувьд сургууль дээрээ үдийн цай бэлтгэх бөгөөд хоол хүнсний зориулалтын байр тоног төхөөхөмжгүй тохиолдолд сургуулийн захиргаа энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах замаар зохион байгуулна.

Нэг: "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зүйлийг анхаарвал зохионо.

- Гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж хэрэгжүүлэх
- Хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, үйлдвэрлэх, боловсруулах, боож савлах, тээвэрлэх зэрэг үйлдвэрлэл үйлчилгээний бүх шатанд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.
- Хүүхдэд олгох хүнсний бүтээгдэхүүн нь боов боорцог, печень хачиртай талх зэрэг гурилан бүтээгдэхүүн, ундааны зүйлд сүүн бүтээгдэхүүн, ундаа жимсний жүүс, халуун цай зэрэг чанартай бүтээгдэхүүн байх.
- Давс болон хийжүүлсэн ундаа, хүнсний нэмэлтүүдийг аль болох хэрэглээгүй байх.
- Удаан хадгалсан, хоносон, амт чанараа алдсан бүтээгдэхүүнээр үйлчлэхгүй байх.

Хоёр: "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээт гүйцэтгэгчийг сонгохдоо дараах шалгуурыг баримтална.

- Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй байх
- Үдийн цай дахь шим тэжээлийн бодис, илчлэгийн хэмжээг БСШУ, Эрүүл мэндийн сайдын 2005 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн 225/296 дугаар хамтарсан тушаалын гуравдугаар хавсралтын дагуу тогтоосон цэстэй байх.
- Хүнсний бүтээгдэхүүн нь шинж, хадгалалтын хугацаа дуусаагүй байх
- Хүнсний бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн шаардлагын дагуу савлах зөөх тээвэрлэх боломжтой байх
- Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэмийг баримтлах нөхцөлийг бүрдүүлсэн байх
- Бүтээгдэхүүнээ цайны цагаас 30 минутын өмнө сургууль дээр авчирсан байх
- Үдийн цайны өмнө хүүхдийн гар угаах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой байх
- Гэрээний хэрэгжилтийг хангах хариуцлага хүлээх чадвартай байх

Гурав: Ерөнхий боловсролын сургуулийн нэг, хоёрдугаар ангийн сурагчдад хичээлийн хоёрдугаар цагийн завсарлагаанаар үдийн цайг ангид нь зохион байгуулж өгнө. Үдийн цайны үргэлжлэх хугацаа 15-20 минут байна.

Сургууль дээр үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, гэрээний биелэлтэд тухайн сургуулийн эмч , эмчгүй сургуулийн хувьд бага ангийн сургалт хариуцсан хичээлийн эрхлэгч өдөр тутмын хяналт тавьж ажиллах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг захирал хариуцна.

Дөрөв: сургуулийн эмч /бага ангийн сургалтын менежер/-ээс дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

- Талуудын гэрээний хэрэгжилтэнд байнгын хяналт тавих, гэрээг дүгнэж захиралд танилцуулах
- Үдийн цайны цэс зохиох ба эрүүл ахуйн хяналт тавих
- Шим тэжээлийн бодис ба зөв хооллох дэглэмийн талаар сурагчдад сургалт явуулах, эцэг эхэд зөвлөгөө өгөх
- Үдийн цайны өмнө анги танхимын ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж буй эсэхэд хяналт тавих
- Үдийн цай бэлтгэж буй ажиллагсдын хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж буй эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил, дутагдлыг тухай бүр нь арилгуулж ажиллах

Аймаг нийслэлийн Боловсрол, соёлын газар сургууль бүрийн үдийн цай зохион байгуулж буй байдалтай хичээлийн жилд 2 удаа, сургуулийн захирал байнгын хяналт тавьж ажиллана.

Сургуулийн захирал, аймаг нийслэлийн Боловсрол, соёлын газраас "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг улирал бүрийн эцэст гаргаж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд танилцуулна.

------oOo------

БСШУ.ЭМ-ийн сайдын 2006 оны 08 дугаар сарын24 өдрийн 336/247–р тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИИН "ҮДИИН ЦАЙ" ХӨТӨЛБӨРИИГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тэдний нас, бие бялдрын онцлог, хэрэгцээнд тохирсон чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан үдийн цайгаар үйлчлэх үйлчилгээг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2 Үдийн цайг эрүүл ахуйн шаардлага хангасан байранд зориулалтын тоног төхөөрөмж, чанарын баталгаатай хүнсний түүхий эд, материал, мэргэжлийн ажилчидтай зориулалтын гал тогоотой сургуулийн хувьд сургууль дээрээ бэлтгэх бөгөөд зориулалтын гал тогоогүй тохиолдолд сургуулийн захиргаа хүнс, хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах замаар тус тус зохион байгуулна.

1.3 Сургуулийн захирал аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээг 2-3 сарын хугацаатай байгуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнэсний /холбогдох хяналтын байгууллагын дүгнэлт/ үндсэн дээр сунгах эсэхээ "Хяналтын комисс"-той хамтран шийдвэрлэнэ.

1.4 Үдийн цайны хүнсний бүтээгдэхүүнийг өдөр болгон татан авах ба хүнсний бүтээгдэхүүнийг сургууль дээр хадгалахыг хориглоно.

1.5 Үдийн цайны бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчаар дамжуулах, хувь хүнээс худалдан авахыг хориглоно.

Хоёр. Үдийн цайг сургууль дээр зохион байгуулах

Ерөнхий боловсролын сургууль дээр үдийн цайны үйлчилгээг дараах байдлаар зохион байгуулна.

2.1 Үдийн цайны цэсийг уг тушаалын хоёрдугаар хавсралтыг үндэслэн долоо хоног бүрээр сургуулийн эмч боловсруулж, сургуулийн захирал батална.

2.2 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад хичээлийн хоёр буюу гуравдугаар цагийн завсарлагаагаар үдийн цайг ангид нь өгнө.

2.3 Үдийн цайны үргэлжлэх хугацаа 15-20 минут байна.

2.4 Үдийн цай уухын өмнө хүүхэд бүрийн гарыг угаалгасан байна.

2.5 Сургуулийн эмч ба багш улирал бүр сурагчдын жин ба өндрийг хэмжиж үнэлгээ, дүгнэлт өгнө.

2.6 Сургууль, эмнэлгийн захиргаа, сургуулийн эцэг эхийн хорооны төлөөлөл бүхий "Хяналтын комисс" байгуулж, үдийн цайны чанар, зохион байгуулалтад байнгын хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг дор бүр нь сургуулийн захиргаанд тавьж шийдвэрлүүлнэ. Хяналтын комиссыг сургуулийн бага ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга ахална.

2.7 Үдийн цайнд тухайн өдөр олгож буй хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч уг мөрдөх журмын дагуу хадгалан, бүртгэл хөтөлнө.

Гурав. Үдийн цайнд олгож хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлага

3.1 Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдпыг хангасан байх,

3.2 Гэрээт гүйцэтгэгчээс нийлүүлж буй нөхцөлд сав, баглаа боодолтой, шошготой байх,

3.3 Амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүн байх,

3.4 Бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх.

Дөрөв. Үдийн цайны цэс зохиоход тавигдах шаардлага

4.1 Сурагчдын эрүүл мэнд, дур сонирхолд нийцсэн байх,

4.2 Цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицлыг зөв сонгосон байх,

4.3 Нэг сурагчийн үдийн цай өдрийн 300 төгрөгт багтсан байх,

4.4 Амархан муудаж чанараа алддаг хүнсний бүтээгдэхүүнийг цэсэд оруулахгүй байх,

4.5 Сүү, цагаан идээ, орон нутагт ургадаг жимс, жимсгэний шүүс, баяжуулсан гурилаар хийсэн хүнсийгтүлхүү оруулсан байх,

4.6 Цэсэнд буй хүнсний бүтээгдэхүүний сард ногдох давтамжийг 2-3 байхаар тооцох,

4.7 Печень, бялуу, шоколад, чихэр зэрэг чихэрлэг бүтээгдэхүүн, давсалсан самар, мөхөөлдөс, түргэн хоол, хийжүүлсэн ундаа оруулахгүй байх,

4.8 Хүйтний улирапд халуун ундааны зүйлээр /халуун аарц/ үйлчлэх,

4.9 Экологийн цэвэр болон аминдэм, эрдэс бодисоор баялаг бүтээгдэхүүнийг сонгох.

Тав. Гэрээт гүйцэтгэгчийг сонгоход баримтлах шалгуур

5.1 Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх,

5.2 Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх,

5.3 Шаардлагын дагуу савлах, зөөж тээвэрлэх боломжтой байх

5.4 Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэмийг баримтлах нөхцөлийг бүрдүүлсэн байх,

5.5 Бүтээгдэхүүнээ цайны цагаас 30 минутын өмнө сургууль дээр авчирсан байх,

5.6 Гэрээний хэрэгжилтээр санхүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх.

Зургаа. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах

6.1 "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн болон Боловсрол, соёлын газар, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран хяналт тавина.

6.2 Сургуулийн үдийн цайны үйлчилгээнд тухайн сургуулийн эмч, эмчгүй сургуулийн хувьд бага ангийн сургалт хариуцсан хичээлийн эрхлэгч өдөр тутмын хяналт тавьж ажиллана.

6.3 Сургуулийн эмч, хичээлийн эрхлэгчээс дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

6.3.2 Талуудын гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт тавих, гэрээг дүгнэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах,

6.3.3 Шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүнийг буцаах

6.3.4 Анги удирдсан багшаар дамжуулан шим тэжээлийн бодис ба зөв хооллох дэглэмийн талаар суралцагчдад сургалт явуулах, эцэг эхэд зөвлөгөө өгөх,

6.3.5 Үдийн цайны өмнө анги танхимын ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж буй эсэхэд хяналт тавих,

6.3.6 Таргалалттай болон жин багадалттай хүүхдэд онцгойлон анхаарал тавих ажлыг өрхийн эмчтэй хамтран зохион байгуулах

6.3.7 Үдийн цай бэлтгэх болон үйлчилж буй ажиллагсад эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан эсэх, хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж буй эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил, дутагдлыг тухай бүр нь арилгуулж ажиллах.

6.4 Үдийн цайны үйлчилгээнд сургуулийн бага ангийн эцэг эхийн зөвлөлийн даргаар ахлуулсан "Хяналтын комисс" хяналт тавина.

6.5 Хяналтын комиссоос хэлэлцэж баталсан хуваарийн дагуу үдийн цайны үйлчилгээний чанарт дараах чиглэлээр хяналт тавина.

6.5.1 Үдийн цайнд олгож буй хүнсний бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэх

6.5.2 Анги танхимын ариун цэвэр болон сурагчдын гарыг угаалгаж буй эсэх

6.5.3 Хүүхдийн дур сонирхол, эрүүл мэндэд тохирч буй эсэх

6.5.4 Цагтаа олгож буй эсэх

6.5.5 Дээж бүтээгдэхүүн авч буй эсэх

6.6 Үдийн цайны үйлчилгээнд хяналт тавьсан Хяналтын комиссын гишүүд үр дүнг сургуулийн захиралд тухай бүр нь танилцуулна.

6.7 Үдийн цайны үйлчилгээний талаар сургуулийн захиргаа улиралд нэг удаа тухайн сурагчдын эцэг эхэд танилцуулж санал бодлыг нь тусгана.

6.8 Сургуулийн захирал, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газраас "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг улирал бүрийн эцэст гаргаж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд танилцуулна.

6.9 Үдийн цайны үйлчилгээг шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй, хүүхдийн эрх ашгийг хохироосон нь эрх бүхий байгууллагын шалгалтаар нотлогдсон байгууллага болон албан тушаалтныг Боловсролын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

БСШУС-н 2006 оны 336/247 тушаалын хавсралт
Ерөнхий боловсролын сургуулийн

"Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам-д оруулсан нэмэлт,өөрчлөлт

1. "Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам"-ын холбогдох хэсгүүдэд дараах заалт, үг, өгүүлбэр нэмсүгэй.

1.1 Журмын 1.2-ийн " ...зориулалтын гал тогоотой сургуулийн хувьд" гэсний ард "заавал" гэж,

1.2 Журмын 1,5-т "Сургуулийн туслах аж ахуйг түшиглэн үдийн цайнд хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэнэ."гэж,

1.3 Журмын 1,6-д "Үдийн цай бэлтгэх ажилд эцэг эх, сурагчдыг оролцуулж болно" гэсэн 2 дахь өгүүлбэрийг,

1.4. Журмын "Үдийн цайны цэс зохиоход тавигдах шаардлага"-ын 4.9-ийн " эрдэс бодисоор баялаг" гэсэн үгийн ард "баяжуулсан "гэж,

1.5 Журмын 4.5-д "Сүү...." гэсний ард "сүүн бүтээгдэхүүн" гэж,

1.6. Журмын "6.5.5 Дээж бүтээгдэхүүн авч" гэсний ард "зориулалтын хөргүүрт хадгалж" гэж

1.7 Журмын 6.5-д "6.5.6 Сургуулийн бие засах газар, угаалгын өрөөний үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт тавих" гэсэн заалт.

2. "Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам"-ын холбогдох хэсгүүдийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2.1 "2.3 Үдийн цайны үргэлжлэх хугацаа 20 минутаас ихгүй байна" гэж,

2.2 "2.5 Сургуулийн эмч улирал бүр сурагчдын эрүүл мэнд, жин, өндрийн судалгааг тогтмол хийж үнэлгээ, дүгнэлт гарган, сургуулийн удирдлага, ангийн багш, эцэг эхэд танилцуулна." гэж,

2.3 "6.3 Үдийн цай зохион байгуулахтай холбогдуулан сургуулийн эмч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ." гэж,

3. "Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам"-ын 1.4 дэх заалтыг хассугай.

БСШУ, ЭМ-ийн сайдын 2010 оны
4/2 дугаар албан даалгавар

Үдийн цайнд өгөхийг хориглосон бүтээгдэхүүн

- Кремтэй, төрөл бүрийн рулет, хавчуургатай бүтээгдэхүүн
- Загас зайдас, хиам, гамбүргер, пицца
- Өндөг, хуурай өндөг, майонез
- Бүх төрлийн өтгөрүүлсэн сироп ашиглаж үйлдвэрлэсэн жүүс
- Төрөл бүрийн гүн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн
- Лаазалсан бүтээгдэхүүн
- Төрөл бүрийн зууш салат шарсан төмс
- Тухайн орон нутагт үйлдвэрлэгдээгүй сүү, сүүн бүтээгдэхүүн